



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/59

Зуунмод

Аймгийн Биеийн тамир, спортын
газрын бүтэц орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 529 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан бүтэц, орон тооны дагуу албан тушаалын тодорхойлолтыг үндэслэн, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Д.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 29 -ны өдрийн А/59 дүгээр
захирамжийн хавсралт

ТӨВ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын зэрэглэл
1. Захиргаа удирдлагын хэлтэс			
1	Газрын дарга	1	ТЗ-4
2	Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТЗ-8
3	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-9
4	Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-9
5	Нягтлан бодогч	1	ТҮ-8
6	Заал зохион байгуулагч, нярав	1	ТҮСБ-3
7	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1	ТҮ-5
8	Жолооч	1	ТҮ-3
9	Жижүүр	4	ТҮ-1
10	Үйлчлэгч	3	ТҮ-1
11	Сахиул	1	ТҮ-1
	БҮГД	16	
2. Биеийн тамирын хэлтэс			
1	Биеийн тамирын хэлтсийн дарга	1	ТЗ-6
2	Хүүхэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүн, төрийн болон төрийн бус байгууллага дахь биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТҮСБ-4
3	Сумдын биеийн тамирын арга зүйч, биеийн тамирын асуудал хариуцсан арга зүйч	1	ТҮСБ-4
	БҮГД	3	
3. Спортын хэлтэс			
1	Спортын хэлтсийн дарга Чөлөөт бөх, үндэсний бөхийн дасгалжуулагч	1	ТЗ-6
2	Самбо, жү-до бөхийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
3	Цана, дугуйн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
4	Сагсан бөмбөгийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
5	Волейболын дасгалжуулагч	1	ТҮСБ-4
6	Пауэрлифтингийн дасгалжуулагч	1	ТҮСБ-4
	БҮГД	6	
	Нийт	25	

оОо